**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2024/130/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Назгүл<br>Утас: 99427301 Цахим хаяг: NazgulD@audit.gov.mn<br>"Уужим алтай Аудит" ХХК-ны Захирал: Б.Галымбек<br>Утас: 99426960 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
  3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
  3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
  3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
  4.1 Ерөнхий зүйл
  4.2 Материаллаг байдал
  4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
  4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Н.БЕЙБИТГҮЛ ТАНАА

2024.02.08 № 60

танай ________-ны № ________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402088

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **110151979.43** | **227926741.04** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 37447428.26 | 158400475.52 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 37447428.26 | 158400475.52 |
| **3121** | **Төгрөг** | 37447428.26 | 158400475.52 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 37447428.26 | 158400475.52 |
| **33** | **АВЛАГА** | 124771.55 | 0.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 124771.55 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 72579779.62 | 69526265.52 |
| **354** | **Хангамжийн материал** | 72579779.62 | 69526265.52 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 375000.00 | 0.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44935372.52 | 47241182.52 |
| 35460 | Хүнсний материал | 10030604.10 | 5046280.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17238803.00 | 17238803.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **264444782.69** | **279673679.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 264444782.69 | 279673679.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 241660782.69 | 255505975.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 205714870.00 | 225614870.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -17552363.52 | -21268739.80 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57991675.00 | 63947665.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -22586138.99 | -34766622.27 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54709173.15 | 65512773.15 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37559850.95 | -44477388.91 |
| 39217 | Ном | 943418.00 | 943418.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 22784000.00 | 24167704.58 |
| 39301 | Програм хангамж | 831421.00 | 2254660.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -831421.00 | -870955.42 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22784000.00 | 22784000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **374596762.12** | **507600420.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **37900.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 37900.00 |
| **413** | **Өглөг** | 0.00 | 37900.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 0.00 | 37900.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 37900.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **374596762.12** | **507562520.79** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 374596762.12 | 507562520.79 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 80600739.00 | 80600739.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 80600739.00 | 80600739.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 291461310.72 | 424427069.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 291461310.72 | 291461310.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 132965758.67 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2534712.40 | 2534712.40 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **374596762.12** | **507600420.79** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **574,876,377.25** | **795,394,239.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **574,876,377.25** | **795,394,239.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 524,657,477.25 | 771,158,839.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 486,670,800.00 | 734,676,000.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 37,986,677.25 | 36,482,839.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,500.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,500.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 50,115,400.00 | 24,235,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,115,400.00 | 24,235,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **515,917,850.93** | **662,428,480.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **515,917,850.93** | **662,428,480.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 514,623,210.93 | 657,534,752.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 372,247,820.19 | 459,040,899.74 |
| 210101 | Үндсэн цалин | 305,951,847.03 | 323,825,179.63 |
| 210102 | Нэмэгдэл | 58,992,856.55 | 119,504,904.00 |
| 210104 | Урамшуулал | 7,303,116.61 | 15,710,816.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,079,800.00 | 79,549,971.55 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,037,900.00 | 54,381,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,760,500.00 | 6,354,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,008,400.00 | 5,082,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 752,200.00 | 1,270,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,520,800.00 | 12,460,971.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,583,360.00 | 17,771,672.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,395,360.00 | 2,525,672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,897,000.00 | 14,746,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 291,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103,500.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 103,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 46,645,298.06 | 61,851,087.10 |
| 210502 | Хоол, хүнс | 46,645,298.06 | 61,851,087.10 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 208,500.00 | 1,570,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 208,500.00 | 1,570,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 420,000.00 | 1,125,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 420,000.00 | 1,125,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,334,932.68 | 36,626,121.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,293,400.00 | 9,643,290.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,786,750.00 | 4,128,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,254,782.68 | 22,853,931.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,294,640.00 | 4,893,728.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,294,640.00 | 4,893,728.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,294,640.00 | 4,893,728.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **58,958,526.32** | **132,965,758.67** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **58,958,526.32** | **132,965,758.67** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **536889700.00** | **758911400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **536889700.00** | **758911400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 486670800.00 | 734676000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 486670800.00 | 734676000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103500.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103500.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 50115400.00 | 24235400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 50115400.00 | 24235400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **499262271.74** | **636358362.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **499262271.74** | **636358362.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **497967631.74** | **631464634.74** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 372372591.74 | 459040899.74 |
| 210101 | Үндсэн цалин | 307704395.03 | 323825179.63 |
| 210102 | Нэмэгдэл | 57350185.00 | 119504904.00 |
| 210104 | Урамшуулал | 7318011.71 | 15710816.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47079800.00 | 79425200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32037900.00 | 54381500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3760500.00 | 6354400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3008400.00 | 5082600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 752200.00 | 1270500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7520800.00 | 12336200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14373160.00 | 17771672.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2395360.00 | 2525672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11520000.00 | 14746000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 457800.00 | 500000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103500.00 | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 103500.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 49202530.00 | 56871053.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49202530.00 | 56871053.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 375300.00 | 1570000.00 |
| 210604 | Урсгал засвар | 375300.00 | 1570000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 752700.00 | 1125000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 752700.00 | 1125000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13708050.00 | 15660810.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9416800.00 | 11890810.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4291250.00 | 3770000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1294640.00** | **4893728.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1294640.00 | 4893728.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1294640.00 | 4893728.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **37627428.26** | **122553037.26** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **180000.00** | **1599990.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **180000.00** | **1599990.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 180000.00 | 1599990.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 180000.00 | 1599990.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-180000.00** | **-1599990.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 37447428.26 | 120953047.26 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 37447428.26 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 158400475.52 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

## АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **80,600,739.00** | **2,534,712.40** | **291,461,310.72** | 374,596,762.12 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **80,600,739.00** | **2,534,712.40** | **291,461,310.72** | 374,596,762.12 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **80,600,739.00** | **2,534,712.40** | **291,461,310.72** | 374,596,762.12 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 132,965,758.67 | 132,965,758.67 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **80,600,739.00** | **2,534,712.40** | **424,427,069.39** | **507,562,520.79** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/Төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 796358900.00 | 633064624.74 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 796358900.00 | 633064624.74 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 796358900.00 | 633064624.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **600683200.00** | **459040899.74** |
| 210101 | Үндсэн цалин | 387814600.00 | 323825179.63 |
| 210102 | Нэмэгдэл | 194697300.00 | 119504904.00 |
| 210104 | Урамшуулал | 18171300.00 | 15710816.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **80250800.00** | **79425200.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54570700.00 | 54381500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6420400.00 | 6354400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5135400.00 | 5082600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1283700.00 | 1270500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12840600.00 | 12336200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22524400.00** | **17771672.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3400800.00 | 2525672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18423600.00 | 14746000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700000.00 | 500000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **71701000.00** | **56871053.00** |
| 210502 | Хоол, хүнс | 71701000.00 | 56871053.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1711000.00** | **1570000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1711000.00 | 1570000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1256700.00** | **1125000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1256700.00 | 1125000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18231800.00** | **17260800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14461800.00 | 13490800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3770000.00 | 3770000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1493587400.00** | **1493587400.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1469352000.00** | **1469352000.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 734676000.00 | 734676000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **24235400.00** | **24235400.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 24235400.00 | 24235400.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **37447428.26** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **158400475.52** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 34.00 | 34.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 23.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэг нь тайлант онд нь "Боловсон хүчнийхээ бүтээмжийг дээшлүүлэх замаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээгээр тэргүүний цэцэрлэг болохыг эрмэлзэх", "Тохилог орчин чанартай сургалт явуулах" гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд  дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн  хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Боловсролын ерөнхий газраас байгууллагын сургалтын алба болон санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133.0 сая төгрөгөөр буюу 35% хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 37,447.4 | 158,400.5 | 120,953.0 |
| Авлага | 124.7 | 0 | -124.7 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 72,579.8 | 69,526.3 | -3,053.5 |
| Үндсэн хөрөнгө | 264,444.8 | 279,673.6 | 15,228.9 |
| **Нийт хөрөнгө** | **374,596.7** | **507,600.4** | **133,003.6** |
| Өр төлбөр | 0 | 37.9 | 37.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 374,596.7 | 507,562.5 | 132,965.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **374,596.7** | **507,600.4** | **133,003.6** |

`

Мөнгөн хөрөнгө оны эцэст 158.4 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 120.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 142.5 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 14.8 сая төгрөг нь нормативт зардал, 1.1 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардлаас үлдсэн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 69,5 сая төгрөг болж оны эхнээс 3,1 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Хүнсний материал 5.0 сая төгрөгийн, аж ахуйн материал 47.3 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 17.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 38,0 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 101,4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр 0.04 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад тооцооны өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 132.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 132.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 734.7 сая, орон нутгийн төсвөөс 24.2 сая, нийт зарлагыг 758.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 540.6 сая төгрөгөөр хянаж, 103.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 127.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 772.1 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 24.2 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 734.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 24.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 37.4 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, нийтдээ 796.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 734.7 сая, орон нутгийн төсвөөс 24.2 сая нийтдээ 758.9 сая төгрөгийн санхүүжилт авч, 37.4 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 633.1 сая төгрөг буюу 83.4 хувьтай буюу дансанд 158.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна.Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийг дэмжих | 1885.0 | 1799.0 | 86.0 | 95.4% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 71701.0 | 56871.0 | 14830.0 | 79.3% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 3905.8 | 3905.8 | 0 | 100% |
| 4 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 1885.0 | 1000.0 | 885.0 | 53.0% |
| 5 | Боловсролын стандарт, сургалтын | 469717.2 | 357839.8 | 111877.4 | 76.2% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 223029.5 | 192307.2 | 30722.3 | 86.2% |
| 7 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 24235.4 | 19341.6 | 4893.8 | 79.8% |
| | **Нийт дүн** | **796358.9** | **633064.4** | **163294.5** | **79.5%** |

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 163.3 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ.Үүнд: цалингийн зардал 141.6 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 0.8 сая, тогтмол зардал 4.8 сая, нормативт зардал 14.8 сая, эд хогшил, урсгал засварын зардал 0.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0,9 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгт 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 83,0 сая төгрөгийн бараа материал, 1,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний захирал Б.Галымбек гүйцэтгэж, анхан шатны хяналтыг хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 515.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 10.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 7,3 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 75%-тай гарсан зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 7,300.0 | 1 | 7,300.0 | 100% |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **7,300.0** | **1** | **7,300.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.Аудитаар нийт 11,9 сая төгрөгийн зөрчил[1] илэрч зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### *1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

*1.1.Илрүүлэлт:*

Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 11,9 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

# Өлгий сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон | 1 | 11,900.0 | | | | | 1 | 11,900.0 | | | | |
| **Дүн** | **1** | **11,900.0** | | | | | **1** | **11,900.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |